

ДЭЛХИЙН II ДАЙНЫ ТӨГСГӨЛ ҮЕ ДЭХ ЗӨВЛӨЛТ-ЯПОНЫ ХАРИЛЦАА

Д.Дашдулам

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Дэлхийн II дайн төгсгөл шатандаа орж, Ази дахь дайны зохиомж японы эсрэг дайнд холбоотон улсууд орох нь тодорхой болоод байлаа. Нэгэнт дайн өргөжих нь гарцаагүй болсон үед Японы талаас холбоотон улсуудтай хийх хэлэлцээрт зуучлагч болох ганц улс бол ЗХУ гэж үзсэн байдаг. Иймд шийдвэрийг гаргахад Японы дипломат албаныхан их үүргийг гүйцэтгэсэн хэдий ч зөвлөлтийн тал хүлээж аваагүй билээ.

Түлхүүр үг: дайн голомт, Подстамын гэрээ, холбоотон улсууд, Алс дорнод, цэргийнхэн, дипломат харилцаа

Европт дайн төгссөн хэдий ч фашист Германы гол холбоотон Япон нь Азид дайтсан хэвээрээ байсан юм. Ийм нөхцөлд Холбоотон улсуудын өмнө тулгарсан ээлжит зорилтуудын нэг бол Японтой хийж буй дайныг түргэн амжилттай дуусгах явдал байлаа. Энэ хүрээнд Холбоотон улсуудын засгийн газраас цэрэг, улс төр, дипломатын олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байдаг. Үүний тод жишээ бол Холбоотон улсуудын удирдагчдын дээд хэмжээний 3 удаагийн бага хурал Тегеран /1943-11-28-12-1/, Крым /1945-2-4-11/, Подстам /1945-7-17-8-2/-ын бага хурлуудыг зохион байгуулсан явдал юм. Эдгээр бага хурлууд нь дэлхийн II дайны түүхэнд онцгой байр суурь эзэлдэг төдийгүй ЗХУ, АНУ, Англи гурван улсын цэргийн болон улс төр, гадаад харилцааны хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

Миний бие энэхүү илтгэлдээ 1945 оны 7 дугаар сарын 26-нд хэвлэгдэн гарсан “Подстамын тунхаглал” хэмээх Японыг үг дуугүй буулгах АНУ, Англи, Хятадын тунхаглал түүнд Зөвлөлт, Японы байр суурь ямар байв гэдгийг чухалчлан тодруулах зорилго тавьсан юм.

Ингэхдээ Подстамын гэрээ байгуулагдахын өмнөх Зөвлөлт-Японы харилцаа ямар байдалд байсан талаар хэдэн зүйлийг хэлэхийг хүсэж байна.

Японы хувьд Зөвлөлт-Германы фронт дээрх сүүлийн үеийн байлдааны ажиллагаа, Крымын бага хурлын шийдвэр¹, 1945 оны 4 дүгээр сарын 5-нд Зөвлөлтийн засгийн газраас 1941 оны 4 дүгээр сарын 13-нд байгуулсан Зөвлөлт-Японы төвийг сахих гэрээг сунгах боломжгүйг мэдэгдсэн² явдал нь ЗХУ нь Японы эсрэг дайнд

¹ Тегеран, Ялта, Подстам баримт бичгийн эмхэтгэл, УБ/1973, 216-217 дахь талууд

² Японы гадаад харилцааны архив, В100 J/R 1, III хавтас

оролцохыг тодорхой болгосон юм. Энэ нь Японы хувьд гэнэт гарсан асуудал биш байлаа. Хэрэв ЗХУ холбоотнуудын хамт Японы эсрэг дайнд оролцвол Япон улс нь дайнд ялагдах нь тодорхой учраас засгийн газар, цэргийнхний хооронд Японд ашигтай нөхцөл болзолтойгоор дайныг дуусгах талаар маргаантай хэвээр байсан юм.

Тэд нар ялангуяа холбоотон улсуудтай энхийн гэрээ байгуулахад зуучлагчаар ямар улсыг сонгох талаар идэвхтэй дипломат бодлого явуулсан байдаг.

Японы "Дайныг удирдах дээд зөвлөл"-ийн 5 дугаар сарын 11-14-нд хуралдсан хурал дээр Хятад, Швейцар, Швед, Ватиканы зуучлах бололцооны талаар авч үзжээ. Оролцогчид эдгээр улсууд АНУ-ын байр суурийг өөрчлөхийг ятгаж чадахгүй гэдэг дээр санал нэгджээ.³ Урт хугацаанд маргалдсаны эцэст Японы талд таатай нөхцөлтэйгээр АНУ, Англитай энхийн гэрээ байгуулахад зөвхөн ЗХУ л зуучлагчийн үүргийг гүйцэтгэж чадна гэж генерал Умезу үзсэн бөгөөд түүнийг Анами, Того нар дэмжжээ.

ЗХУ-ыг зуучлагчаар сонгож авснаар Японы тал өөр илүү чухал зорилго тавьсан. Энэ нь Японы зүгээс илүү таатай харилцааг бий болгосны үндсэн дээр ЗХУ-ыг ямар ч хамаагүй үнээр дайнд оруулахгүй байх явдал байлаа.

Японы дипломатууд Зөвлөлт-Японы Төвийг сахих гэрээг шинэчилсний хариуд Японы зүгээс Өмнөд Сахалиныг өгөх, Порт-Артур, Дальний /Даолян/ боомтыг түрээслэх, загас агнуурын гэрээнээс татгалзах, Хойд Манжуурын төмөр зам эзэмших эрхээс татгалзах, Зүүн хойд Хятад болон Өвөр Монголоос цэргээ гаргах, Цугару-ын хоолойгоор Зөвлөлтийн усан онгоцыг нэвтрүүлэх болзлуудыг тавьсан юм. Онцгой нөхцөлд Курилын арлын хойд хэсгийг ЗХУ-д шилжүүлэхийг зөвшөөрсөн байна.⁴

Японы талаас "тал зассан" шалтгаан нь хэрэв ЗХУ дайнд орвол өөртөө ашигтайгаар дайныг дуусгах эцсийн боломжоо алдах байв.

Дээд офицерууд Зөвлөлтийн зэвсэгт хүчнийг бодитойгоор үнэлж байсан тул тэд Того-гоос "Оросыг дайнд оруулахгүй байхад чадах бүхнээ хийхийг хүсэж байв."⁵

Япончууд фашист германыг бууж өгсөний дараа бий болсон олон улсын хурцадмал байдлыг зөвөөр тодорхойлж чадаагүй юм. Тэд нар зөвлөлтийнхэнтэй

³ S. Todo. The Cause of Japan, New York, 1956, p286

⁴ G. Lensen . The strange Neutrality: Soviet-Japanese Relations during the Second World War 1941-1945, 1972, p. 134

⁵ S. Todo. The Cause of Japan, New York, 1956, p. 279

төвийг сахих асуудлыг “наймаалцаж” болно гэж тооцож байсан нь ихээхэн эндүүрэл байсан юм.

Харин Гадаад явдлын яамны сайд Того Шигенори үүнд шүүмжлэлтэй хандаж байлаа. Тэрбээр улс төрийн зүтгэлтэн, гадаад яамны туршлагатай ажилтан байсан төдийгүй Герман, Зөвлөлтөд элчин сайдаар ажиллаж байхдаа “Япон-Зөвлөлтийн загас агнуурын гэрээ, Халхын голын дайны дараах Зөвлөлт-Японы хэлэлцээрт оролцож байсан учраас Зөвлөлтийн талын сонирхол, байр суурийг сайн мэдэж байлаа. Того нь Японы зүгээс өмнөх жилүүдэд ЗХУ-тай харьцахдаа хэрцгий харьцаж байсан явдал нь найрсаг хандах бололцоог үгүй болгосон гэж үзэж байв. Гэхдээ тэрбээр ЗХУ нь зуучлагчийн үүрэг гүйцэтгэх боломжтой гэж үзсэн юм. Энэ үүргийг гүйцэтгэхэд ерөнхий сайд, гадаад хэргийн сайд байсан Хирота Кокиг л чадна гэж үзэж байлаа.

6 дугаар сарын 3-нд Хирота Японд суугаа зөвлөлтийн элчин сайд Я.А.Маликтай Гёра /Хаконэ дүүрэг/ хэмээх амралтын газар уулзсан байна. Ингэхдээ Алс Дорнодод тогтвортой байдлыг сахихад ЗХУ-тай харилцан ойлголцолд хүрэх Японы засгийн газрын хүсэлтийг дамжуулсан байна. Дараагийн өдрийн уулзалтаар Хирота гэрээ албан ёсоор эхэллээ гэж ойлгож байна хэмээн хэлэхэд Зөвлөлтийн элчин сайд Я.А.Малик баримтлах хатуу байр сууриа илэрхийлсэн тул Хиротагын оролдлого бүтэлгүйтсэн байна. Гэвч хэдэн өдрийн дараа Хирота зөвлөлтийн ЭСЯ-нд ирж Маликтай уулзан, Японы зүгээс тавих тодорхой саналыг дамжуулжээ. Тухайлбал, 6 дугаар сарын 24-ны уулзалтаар ЗХУ-аас нефть нийлүүлсэн тохиодолд зарим 1 стратегийн ач холбогдолтой зүйл нийлүүлж болох тухай мэдэгджээ. Мөн 6 дугаар сарын 29-нд Хиротагаас ЗХУ-Японы хооронд Алс Дорнодод энхийг сахиулах гэрээний талаар Маликийн байр суурийг мэдэх гэж оролджээ.⁶ Гэвч дайныг дуусгах талаар тодорхой асуудал дурдаагүй тул ЗХУ хүлээн аваагүй байна. Үүний дараа Японы засгийн газар ЗХУ-ыг өөрийн албан ёсны төлөөлөгчтэй хэлэлцээр байгуулах шийдвэр гаргасан. Дайныг удирдах дээд зөвлөлөөс 7 дугаар сарын 10-нд Москвад хийх хэлэлцээрийг Коноэд даалгасан байдаг. 7 дугаар сарын 12-нд Элчин сайд Сато Наотакэгаас ГЯЯ-ны орлогч сайд С.А.Лозовскийд Коноэгийн тэргүүлсэн төлөөлөгчдийг хүлээн авахыг ЗХУ-аас хүсэхийн хамт Япон улс дайныг эцэс төгсгөл болгох хүсэлтэй байгааг илэрхийлсэн эзэн хаан Хирокитогийн илгээмжийг гардуулжээ.

⁶ Кутаков. Л., История советско-японских дипломатических отношений, М, 1962, стр. 448-449

Зөвлөлтийн тал дээрх хоёр баримтыг судлаад Японы дээд удирдлагад онцгой өөрчлөлт ороогүй, төдийгүй Коноэгийн төлөөлөгчдийн зорилго, шалтгаан түүний эрхийг тодорхой тусгаагүй тул зөвлөлтийн засгийн газар тодорхой хариуг хэлж чадахгүй хэмээн 7 дугаар сарын 18-нд С.А.Лозовскийгаас Сатод мэдэгджээ.⁷

1943 оноос хойш ЗХУ Элчин сайдын алба хашиж буй Сатогоос нөхцөл байдлыг судалсаны үндсэн дээр эзэн хааны удирдлагад Япон үг дуугүй бууж өгөх шийдвэр гаргахыг зөвлөжээ.⁸ Гэвч Токио энэ зөвлөмжийг хүлээж аваагүй төдийгүй дайны эцсийн өдөр хүртэл ЗХУ-ыг зуучлагчийн үүргийг гүйцэтгэхэд татан оролцуулна гэж итгэсээр байсан юм.

Ер нь 1945 оны 5-8 дугаар сард Японы дээд удирдлагынхан дотор энхийн гэрээ байгуулах талынхан дайныг үргэлжлүүлэх талынханаас илүү хүчтэй байсан гэж хэлж болох юм. Потсдамын тунхаглал гарахаас өмнө Японы цэргийнхэн дотор үг дуугүй бууж өгөх Кайрын бага хурал /1943-11-27/-ын болзол хэрэгжихгүй байх гэж ихэнх нь бодож байжээ.

7 дугаар сарын 26-нд АНУ, Англи, Хятадын удирдагчид Японыг үг дуугүй буулгаж авах тухай 13 зүйл бүхий Потсдамын гэрээнд нэгдэн оржээ.⁹ ЗХУ нь Японтой дайны ажиллагаа явуулаагүй тул тунхаглалд хараахан нэгдэн ороогүй байсан юм. Гэвч Зөвлөлтийн тал Японы эсрэг дайнд холбоотнуудын хамт оролцох хэдий ч дайны ажиллагаанд 8 дугаар сарын дундуур орно гэж тооцож байлаа.

Потсдамын гэрээнд оролцсон зөвлөлтийн төлөөлөгчид 8 дугаар сарын 5-нд тусгай галт тэргээр Москвад иржээ. Элчин сайд Сато Токиод хурлын үр дүнгийн талаар мэдэгдсэн бөгөөд хэдэн өдрийн дараа буюу 8 дугаар сарын 8-нд Зөвлөлтийн гадаад хэргийн яамныхантай орой 17 цагт уулзжээ. Молотовоос "Герман ялагдсаны дараа Япон нь одоо хүртэл дайныг үргэлжлүүлж байгаа их гүрэн юм. 7 дугаар сарын 26-ны Японы цэргийн үг дуугүй бууж өгөх тухай Америк, Их Британи, Хятад гурван гүрний шаардлагыг Япон хэрэгсэхгүй болгосныг харгалзан ... Японы түрэмгийллийг эсэргүүцэн дайнд оролцон түүгээрээ дайны төгсгөлийн хугацааг богиносгон хохирлыг багасгаж, бүх нийтийн энх амгаланг түргэн сэргээхэд тусална уу гэж холбоотнууд Зөвлөлт улсын засгийн газарт хүссэн юм. Холбоотны өмнө хүлээсэн үүрэгтээ үнэнч Зөвлөлт засгийн

⁷ Мөн тэнд стр. 453

⁸ S.Todo. The Cause of Japan New York, 1956, p. 308

⁹ War with Japan, Vol. VI, The Advance to Japan, p. 283

газар холбоотны хүсэлтийг хүлээн авч энэ оны 7 дугаар сарын 26-нд тавьсан холбоотон гүрний мэдэгдэлд нэгдэв."¹⁰ Дээр дурьдсанаас үндэслэн 8 дугаар сарын 9-нөөс эхлэн ЗХУ өөрийгөө Японтой дайтаж байгаа гэж үзнэ хэмээжээ.

Зөвлөлтийн удирдлага ЗХУ-ыг дайнд оролцох хугацааг 8 дугаар сарын дундуур хэмээн тооцож бэлтгэлээ хангаж байсан ч урагшуулуулах зайлшгүй нөхцөл байдал тулгарчээ. Үүнд: 1945 оны 8 дугаар сарын Зөвлөлт Хятадын гэрээ, 8 дугаар сарын 6, 9-ны Хирошима, Нагасаки дахь атомын бөмбөгийн дэлбэрэлтийг хэлж болох юм. Мөн АНУ-аас Японд явуулах дайны ажиллагааны төлөвлөгөөнөөс харж болох юм. Японы эсрэг дайнд ЗХУ оролцох шийдвэр гаргасны дараахан буюу 8 дугаар сарын 11-нд Холбоотныг төлөөлөх дээд командлагчаар Макартурыг томилох саналыг Труменээс тавьсан байдаг.¹¹

Ер нь Холбоотны цэргийн ажиллагаа өргөжихийн хирээр АНУ-ын зүгээс Зөвлөлтийн цэргийн үйл ажиллагааг хязгаарлах гэсэн оролдлогуудыг хийж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал: Крымын бага хурлын үед үндсэнд нь тохиролцсон Курилын арлыг уг төлөвлөгөөгөөр АНУ мэдэлдээ аван цэрэг болон худалдааны бааз байгуулах шийдвэрийг ЗХУ эсэргүүцэн энэ талаар Крым, Берлин бусад үед ямар ч хэлбэрээр мэдэгдээгүй байсныг анхааралуулан сануулсан генералиссимус Сталинаас Ерөнхийлөгч Трумэнд 8 дугаар сарын 15-нд бичсэн нэгэн баримт байдаг. Уг баримтанд бичсэнээр: "Энэ маягийн шаардлага нь ялагдсан оронд эсвэл өөрөө өөрийгөө хамгаалж чадахгүй болоод өөрийн холбоотондоо хүсэлт тавьсны хариуд тавьдаг шаардлага юм. ЗХУ ийм орны тоонд орохгүй байх"¹² гэжээ. Крымын бага хурал дээр ЗХУ дайнд оролцох талаар болзол тавьж Англи, Америкийнхан хүлээн зөвшөөрсөн юм. Тухайн үеийн нөхцөл байдал Потсдамын хурлын үеийнхээс тэс өөр байв. Тэр үед герман бууж өгөх нь тодорхой биш, дайнд ялахад 18 сарын хугацаа шаардлагатай төдийгүй 1 сая хүний бүрэлдэхүүнтэй армийг Японы эсрэг илгээх төлөвлөгөөтэй байв. Холбоотнууд Японы армийг эцсээ хүртэл фанатик маягаар тулалдана гэж бодож байлаа. Холбоотонууд Японы армийн хүчин чадал багассан гэж

¹⁰ Монгол Японы харилцаа, эрт эдүгээ, УБ 2001, 96 дахь тал

¹¹ Переписка председателя Совета министров СССР с президентами США и премьер министрами Великобритании во время Великой отечественной войны 1941-1945 гг., М 1958 стр. 257

¹² Мөн тэнд, стр. 264

сайн мэдээгүй төдийгүй тулалдаанд ихээхэн хохирол амсана гэж тооцож байлаа. Потсдамын хурлын үед ч 2 талаас тус бүр 1 сая орчим хүний хохирол амсана гэж үзсэн ба харин Черчилль хүн хүчний хувьд хагас сая орчим хүнээ алдана гэж бодож байлаа. Ийм үед Зөвлөлтийн тусламжтайгаар л хохирлыг багасгаж чадна гэж үзсэн. Хэрэв Зөвлөлтийн тал дайнд оролцохгүй төвийг сахисан байдалтай байвал Манжуур дахь Квантуны арми урагшаа давшилтанд орж холбоотны байдлыг хүндрүүлнэ гэж бодсон юм. Үүнийг Зөвлөлтийн тал ашиглаж дайнд оролцох болзолуудаа тулган хүлээлгэсэн юм. Энд онцлон тэмдэглэхэд энэ болзлуудын 1-рт Монголын тусгаар тогтнолыг холбоотнуудаар хүлээн зөвшөөрүүлж чадсан явдал нь ихээхэн ач холбогдолтой зүйл болсон билээ. ЗХУ Потсдамын тунхаглалд нэгдэн орж Японтой дайтсан явдал нь Алс Дорнод дахь хүчний харьцааг тогтворжуулж, дайны төгсгөлийн явцыг хурдасгаж энэ бүс нутагт энх тайвныг тогтоож өгснөөрөө үнэлж баршгүй ач холбогдолтой зүйл болсон билээ.

Японы хувьд дайнд ялагдах нь тодорхой болмогц дайны төгсгөлийг Японд ашигтай байдлаар эргүүлэн АНУ, Англитай салангид гэрээ байгуулахыг дипломат бүх арга замаар сүвэгчилсэн байдаг. Ингэхдээ энэхүү гэрээг байгуулахад зөвхөн ЗХУ зуучлагчын үүргийг гүйцэтгэж чадна гэж үзсэн байдаг. Гэвч ЗХУ энэхүү хүсэлтийг нь хүлээж аваагүй явдал нь Японы ялагдах бас нэгэн баталгаа болсон юм.

Abstract: At the final stage of the Second World War it was evident that the Allies were about to launch an offensive against Japan. In this desperate situation, Japan sought the USSR as its only possible mediator in negotiating with the Allied Powers to talk them out of this plan. Despite enormous efforts of Japanese diplomacy, the Soviets have never accepted their terms.